



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/610

Номгон

Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох,
хяналтыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", 29.2, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 32.1.1, Засгийн газрын 43 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 66 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Тус аймгийн Хүрээмарал, Жинст, Шинэжинст, Баацагаан, Баян-Овоо, Өлзийт, Богд, Бууцагаан сумдад мал, амьтны гоц халдварт "Шүлхий" өвчин батлагдаж, уг халдварын голомтыг устгах, халдварын тархалтыг таслан зогсоох, цаашид тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс өвчний голомтыг устгах хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Дээрх хугацаанд өвчний голомттой сумуудаас бусад сумруу мал, мах тээвэрлэх, тууварлах, худалдахыг хориглож, дээрх сумдад шалган нэвтрүүлэх хяналтын пост нэмэлтээр ажиллуулж, хяналт, шалгалтыг сайжруулж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-т,

3.Бусад аймгуудаас мал, мах худалдан авах, малын отор нүүдэл, тээвэрлэлтэд хатуу хяналт тавьж, шүлхий өвчний тархвар зүйн судалгаа хийх, дархлаажуулах, халдварыг таслан зогсоох, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах, мөн мал амьтны гоц халдварт шүлхий өвчин гараагүй сумдаас мал эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан гэрчилгээтэй махыг иргэдийн хүнсний хэрэгцээнд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



МӨНХСАЙХАН

601210423